



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН

*ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН*

# 2024





## Агуулга

- 01 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
- 02 АРИЛЖААЛАГДАЖ БУЙ ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 03 ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ
- 04 МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ
- 05 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

*ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ*

- Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл
- Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл
- Хүснэгт 3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл
- Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч
- Хүснэгт 5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээ
- Хүснэгт 6. Нийт орлогын тайлан

*ЗУРГИЙН ЖАГСААЛТ*

- Зураг 1. Хувьцаа эзэмшлийн бүтэц
- Зураг 2. ТУЗ-ийн гишүүдийн бүтэц
- Зураг 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
- Зураг 4. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо
- Зураг 5. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Зураг 6. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Зураг 7. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв
- Зураг 8. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ
- Зураг 9. Нийт харилцагчдын мэдээлэл
- Зураг 10. Баталгаажуулалт хийсэн харилцагчийн төрөл

## Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий танилцуулга


2024 онд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)–нд нэр бүхий 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлтэй байна.

Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо	Арилжааны платформын хаяг	Үйл ажиллагааны чиглэлийн тоо
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	6210139	2017.08.01	2022.09.21	Trade.mn	5
2	“Койн Хаб” ХХК	6693326	2021.04.06	2022.09.21	Coinhub.mn	5
3	“Айдакс” ХХК	6803016	2021.12.30	2022.09.21	Idax.exchange	5
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	3645789	2021.09.23	2022.10.10	Ncx.mn	3
5	“Корэкс” ХХК	6752586	2021.09.07	2022.10.10	Corex.mn	5
6	“Икс Мета” ХХК	6784771	2021.11.18	2022.10.10	X-meta.com	5
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	6719791	2021.06.20	2022.10.10	Complex.mn	5
8	“Чойжин Алтекс” ХХК	6785123	2021.11.18	2022.10.10	Altex.mn	5
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	6671845	2021.03.04	2022.10.10	Zoos.digital	5
10	“Капекс капитал” ХХК	6792987	2021.12.07	2022.11.25	Capex.mn	3
11	“Анд дэнөүд” ХХК	6783147	2021.11.12	2022.11.25	Denode.io	5
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	6906834	2022.08.25	2023.01.13	Octagon.mn	5


Дээрх 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс 11 нь Улаанбаатар хотод байршилтай бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байршилтай байна. Түүнчлэн 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–т заасан 5 үйлчилгээг үзүүлэхээр, “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК болон “Капекс капитал” ХХК нь виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах гэсэн 3 үйлчилгээг үзүүлэхээр бүртгэл хийлгэсэн.

Зураг 1. Хувьцаа эзэмшлийн бүтэц




12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийт 23 хувьцаа эзэмшигчтэй ба 8 нь хувь хүн, 15 нь хуулийн этгээд байна. Мөн “Комплекс Дижитал Экосистем” ХХК-ийн 10%-ийг “Bittrex Global GmbH” LLC гэх гадаад хуулийн этгээд эзэмшиж байна.

Зураг 2. ТУЗ-ийн гишүүдийн бүтэц




12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийт 71 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй бөгөөд 46 нь хараат, 25 нь хараат бус гишүүн байна.

Зураг 3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ



## ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоод болон гадаад виртуал хөрөнгийн тоо

Зураг 4. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо




2024 онд бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан нийт 645 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа бөгөөд үүнээс 42 дотоодын виртуал хөрөнгө, 603 гадаадын виртуал хөрөнгө байна. Нийт арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн 93%-ийг гадаадын виртуал хөрөнгө эзэлж байна.


## ВХҮҮ-ийн арилжааны зохион байгуулалт

Зураг 5. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)

■ 2023 оны дөрөвдүгээр улирал  
■ 2024 оны дөрөвдүгээр улирал



Зураг 6. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)




Хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан 2024 онд гадаадын виртуал хөрөнгийн 1.96 их наяд төгрөгийн, дотоодын виртуал хөрөнгийн 61.6 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдэж, нийт арилжааны дүн өмнөх оноос 60.5 хувиар өссөн байна. Мөн “Чойжин Алтекс” ХХК, “Анд Дэнөүд” ХХК дээр дотоодын виртуал хөрөнгө, “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК дээр гадаад, дотоод виртуал хөрөнгийн арилжаа тус онд хийгдээгүй болно.


**ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоодын виртуал хөрөнгө**

Зураг 7. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв

Дотоодын виртуал хөрөнгөөс “IHC, ARDX” нь хамгийн олон буюу 5 ВХҮҮ дээр, “ZESC” 4 ВХҮҮ дээр, “SPC, ADMC” нь 3 ВХҮҮ дээр, “OBOT, MONT, WPL, MNFT” нь 2 ВХҮҮ дээр үлдсэн нь зөвхөн 1 ВХҮҮ дээр тус тус арилжаалагдаж байна.



Зураг 8. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ (тэрбум төгрөг)



Өмнөх онтой харьцуулахад арилжааны хэмжээ 2024 оны 3 дугаар сараас эхлэн өсөлттэй байсан бөгөөд АНУ-ын Үнэт цаасны хорооноос Bitcoin spot (ETF), Ethereum (ETF)-ийг баталсан, мөн АНУ-ын ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсон зэрэг үйл явдлууд нь тухайн зах зээлийг өсөлттэй байхад нэлээдгүй нөлөө үзүүллээ. 2024 онд дотоодын виртуал хөрөнгийн арилжаа 55 хувиар буурсан бол гадаад виртуал хөрөнгийн арилжаа 75 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



## Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

№	Виртуал хөрөнгийн нэр	Анхны ханш	Бүх цаг үеийн хамгийн доод ханш	Бүх цаг үеийн хамгийн дээд ханш	2024.12.31-ний байдлаарх ханш	2024.01.01-12.31 хүртэл нийт арилжааны хэмжээ (төгрөгөөр)	Зах зээлийн үнэлгээ
1	ADMC	1	0.01	1.49	0.18	7,100,990.95	2,864,612,723.31
2	ARDX	1	0.79	445.00	32.7	26,853,157,269.13	40,718,713,288.43
3	ARDT	4600	2000.01	5199.00	2900.00	84,060,160.80	21,396,259,910.52
4	BES	0.14	0.02	199.92	0.02	19,545.87	699,826.5
5	BID	0.4	0.0001	0.79	0.32	4,218,703.16	1,257,340,212.69
6	CHB	30	3.2	248.8	14.36	1,908,230,924.70	11,866,995,127.94
7	IHC	0.30	0.06	6.34	0.09	6,593,535,939.28	53,343,435,061.94
8	SPC	0.2	0.087	2.99	0.29	15,860,148,774.27	10,137,559,240.87
9	MNFT	0.3	0.0106	49.5	0.041	1,524,698,885.76	4,173,362,775.17
10	MNDT	1.00	1.00	1.00	1.00	18.726.18	1,649,142.44
11	EAC	0.01	0.001	0.007	0.001	8,401,669.57	341,878,790.94
12	DAC	0.33	0.003	0.513	0.013	9,696,128.46	30,903,774.46
13	WPL	1	0.006	1.4297	0.035	23,023,113.37	396,378,009.34
14	ELFC	0.3	0.003	0.3	0.0088	14,282,806.65	559,519,935.23
15	ICTG	130	0.01	180.00	30.00	14,892,806.46	4,218,016,975.99
16	DC	1.20	0.14	4.00	0.15	11,950,405.73	178,371,234.49
17	ZESC	1.00	0.0532	107.9	0.18	70,298,895.01	329,233,633.07
18	OBOT	114	5.053	285.00	67.5	3,165,535,985.96	11,248,065,517.8
19	MONT	1.00	1.00	1.00	1.00	53,756,733.27	257,705,244.72
20	TRD	1.00	0.001	55.00	0.19	252,172,086.87	3,880,403,781.05
21	NTC	0.5	0.04	1.00	0.4	75,310,408.3	5,658,419,017.91
22	CRX	15	0.29	30.1	0.7	39,247,876.49	268,241,133.04
23	ZOOS	1.00	0.55	0.55	-	-	133,446,223.6

24	CPX	0.25	0.0004	0.5004	0.009	3,112,305.59	88,175,821.74
25	GER	0.1	0.0001	0.1	0.032	4,337,560.64	126,459,073.64
26	CARE	0.15	0.0001	0.15	0.04	279,481.98	29,846,640.06
27	CAEL	2.85	0.013	3.9941	0.08	183,316.46	79,349,529.85
28	BDC	70	0.0492	127.95	19.9	1,256,792.71	3,360,297.97
29	CAMEL	0.2	0.0012	0.9996	0.4	11,099.70	16,811,774,065.3
30	MSC	0.25	0.0011	0.35	0.23	6,935,886.61	277,868,306.07
31	MOZO	0.3	0.0004	0.5398	0.059	5,143,337.62	252,885,059.26
32	MGLC	0.89	0.011	4.993	0.011	-	70,129,135.01
33	IIT	3.00	0.013	3.993	0.007	37,195.00	10,896,376.42
34	URGX	1	0.0001	3.00	0.1009	290,362,994.46	779,194,955.40
35	DAXT	1ARDT= 1ARDX	16.00	55.68	25.92	130,196,340.12	885,955,663.44
36	ARDM	0.039	0.005	0.181	0.013	235,894,649.76	1,954,236,609.53
37	BS9	1000	880.00	2000.00	2000.00	2,312,107,408.38	57,750,857,598.91
38	A100F	1.15	32.00	192.00	114.24	436,555,714.98	1,727,714,206.94
39	A44L	1.2	28.8	112	45.1	346,067,426.32	860,112,108.13
40	A55M	1.15	35.21	156.8	52.8	724,118,864.7	1,532,873,486.5
41	A77G	1.2	33.09	153.6	48	289,908,945.48	1,439,863,598.4
42	A45N	1.1	30.4	60.8	53.12	199,062,560.52	355,195,963.52

2024 онд бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр арилжаалагдаж буй дотоодын 42 виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 258.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 6.8 хувиар өссөн байна. Мөн дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа өмнөх оноос 12 хувиар өсөж, 168.6 сая төгрөг болсон байна.

(A100F, A44L, A55M, A77G, A45N гэх виртуал хөрөнгүүдийн ханш нь ARDX-ээр илэрхийлэгдсэн ханш болно.)

## Харилцагчийн мэдээлэл

2024 онд бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр давхардсан тоогоор нийт 932,252 харилцагч бүртгэлтэй бөгөөд өмнөх оноос 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл


№	Хуулийн этгээдийн нэр	Бүртгэлтэй харилцагч	Батгалгаажуулалт хийсэн харилуагч	Идэвхитэй арилжаа хийдэг харилцагч
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	222,919	84,424	3,541
2	“Койн Хаб” ХХК	201,128	120,309	4,515
3	“Айдакс” ХХК	196,159	133,876	2,404
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	13,879	4,977	14
5	“Корэкс” ХХК	65,509	30,523	15
6	“Икс Мета” ХХК	21,113	10,920	1,326
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	128,716	53,783	1,940
8	“Чойжин Алтекс” ХХК	1,087	489	60
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	2,228	1,183	0
10	“Капекс капитал” ХХК	32,887	16,001	186
11	“Анд дэнөүд” ХХК	3,373	641	9
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	43,254	2,538	1
Нийт		932,252	459,664	14,011

## Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч


№	Хуулийн этгээдийн нэр	НИЙТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД				
		Дотоодын иргэн	Дотоодын хуулийн этгээд	Дотоодын улс төрд нөлөө бүхий этгээд	Гадаадын иргэн	Гадаадын хуулийн этгээд
1	“Дижитал Эксчөйнж Монголиа” ХХК	84,170	8	226	20	0
2	“Койн Хаб” ХХК	120,103	26	20	159	1
3	“Айдакс” ХХК	90,098	20	0	43,758	0
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	4,964	2	0	11	0
5	“Корэкс” ХХК	30,513	10	0	0	0
6	“Икс Мета” ХХК	10,724	1	1	194	0
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	53,554	9	220	0	0
8	“Чойжин Алтекс” ХХК	479	10	0	0	0
9	“Зоос Дижитал Эксчөйнж” ХХК	1,183	0	0	0	0
10	“Капекс капитал” ХХК	15,583	0	0	418	0
11	“Анд дэнөүд” ХХК	638	2	0	1	0
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	2,538	0	0	0	0

Нийт бүртгэлтэй харилцагчаас 49.3 хувь буюу 459,664 нь баталгаажуулалт хийсэн харилцагч байна.


Зураг 9. Нийт харилцагчдын мэдээлэл




Зураг 10. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал



Насны бүлгээр




Хүйсээр



Нийт баталгаажуулалт хийсэн харилцагчийн 85 хувийг 16–45 насны харилцагчид эзэлж байна.

## Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл



Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ын дагуу үнэлсэн.

Хүснэгт 5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээ

ЭРСДЭЛ МАШ БАГА	ЭРСДЭЛ БАГА	ЭРСДЭЛ ДУНДАЖ	ЭРСДЭЛ ӨНДӨР
“Поверэд Эй Ди Эм” ХХК (octagon.mn)	“Чойжин Алтекс” ХХК (altex.mn)	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК (trade.mn)	-
-	“Корэкс” ХХК (corex.mn)	“Икс Мета” ХХК (x-meta.mn)	-
-	“Анд дэнөүд” ХХК (denode.io)	“Койн Хаб” ХХК (coinhub.mn)	-
-	“Капекс капитал” ХХК (capex.mn)	“Айдакс” ХХК (idax.exchange)	-
-	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК (zoos.digital)	“Комплекс Дижитал Экосистем” ХХК (complex.mn)	-
-	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК (ncx.mn)	-	-

2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн үнэлгээний үр дүнгээр салбарын оролцогчдын 41.6% буюу 5 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь цаашид эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тус 5 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлийн үнэлгээг байгууллагын хэмжээ, арилжааны дүн, арилжаанд оролцогчдын төрөл зэрэг хүчин зүйлс нэмэгдүүлж байгаа буюу бизнесийн болон бүтцийн эрсдэл өндөртэй байна.

## ВХҮҮ–ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2024 оны санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтээр нийт хөрөнгийн дүн 77.9 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгө 57.7 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 20.2 тэрбум төгрөг байна. Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41.3 хувиар, эргэлтийн хөрөнгө 67.1 хувиар тус тус өсөж, харин эргэлтийн бус хөрөнгө 1.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн 77.9 тэрбум төгрөг, өр төлбөрийн дүн 54.1 тэрбум төгрөг, эздийн өмчийн дүн 23.8 тэрбум төгрөг байна. Тайлант улиралд нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн өмнөх оноос 41.3 хувиар, эздийн өмч 2.9 хувиар, өр төлбөр 69.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2023.12.31  
2024.12.31

## НИЙТ ХӨРӨНГӨ (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)



## ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)



## Хүснэгт 7. Нийт орлогын тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,919,312,048.66	6,845,874,00.88
2	Борлуулалтын өртөг	1,575,189,606.00	1,256,994,461.59
3	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)	(10,932,396,938.24)	1,174,432,847.89
4	Нийт орлогын дүн	6,065,811,352.62	13,407,428,639.13
5	Нийт зарлагын дүн	16,998,208,290.86	12,232,995,791.24

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт орлогын дүн 13.4 тэрбум төгрөг, нийт зардал 12.2 тэрбум төгрөг байна. Мөн тус онд 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийт 1.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаас гадна орлогын дүн 7.3 тэрбум төгрөгөөр өсөж, зардал 4.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



Засгийн газрын 4 байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-261674



[www.frc.mn](http://www.frc.mn)



[vaspd@frc.mn](mailto:vaspd@frc.mn)



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia